## 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

### 1. Тухайн жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга

“Хатант интернэшнл” ХХКомпани нь эх орныхоо унаган байгалиас нөхөн сэргээгддэг, натурал түүхий эд боловсруулан үйлдвэрлэж бүх шат дамжлагадаа нэмүү өртөг үүсгэн нийгмийн хариуцлагаа дээдлэн ажилладаг. Бид түүхий эд материалаа Монгол улсын баруун бүс нутгаас татан боловсруулахаас гадна Улаанбаатар дахь өөрийн салбараар дамжуулан зүүн болон төв аймгуудын түүхий эдийг үйлдвэр дээрээ татан төвлөрүүлдэг юм.Үйлдвэр нь жилийн хэрэгцээт түүхий эдээ цаг тухайн үед нь хангалттай хэмжээгээр нөөцөлж авахын тулд бэлтгэн нийлүүлэгчдийн цар хүрээг малчдын нөхөрлөл хоршоодтой шинээр түнших замаар шийдвэрлэж,аажимдаа малчид үйлдвэртэй шууд харьцдаг хэлбэрт оруулах асуудал бидний эрхэм зорилго юм.

2023 онд ноос,ноолуур угаах,самнах үйлдвэрийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхний 9 сарын байдлаар нийт 438,9 тонн ноолуур угааж,110 тонн ноолуур самнах боловсруулалтыг хийж Итали улс руу 200 тонн самнасан ноолуурыг бэлтгэх гэрээг хийсэн бөгөөд үүнээс 80 тонн ноолуурыг экспортод гаргалаа.

### .2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

| Үйлдвэрийн Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | 2023 оны төлөвлөгөө | | Төлөвлөгөөний биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Нийт зардал, мян.төг | Тоо хэмжээ /5 жил/ | Хийгдсэн ажил | Зарцуулсан хөрөнгө мян. төг | Баталгаажуулалт |
| Ажлын байранд ариутгал халдваргүйтгэл хийх зөвлөмж | 100.0 | 5 | Гэрээт байгууллага "Санитар төв" ХХК-иар 2023.08.24-нд үйлдвэрийн уурын зуух,гадна талын агуулахууд,шингэн бохир ус болон хатуу хогийн цэг, угаах,ялгах,самнах цехүүд, амрах байр,оффисийн барилга, ажлын байранд гэрээт байгууллагаар ариутгал халдваргүйтгэл хийлгүүлсэн. | **400,0** | Хавсралт 1 |
| Борооны усыг хуримтлуулан ногоон байгууламжийг услах | 500.0 | 5 | Оффисийн барилгын баруун зүүн талын борооны усыг зайлуулах цэгт 1 тонны багтаамжтай 2 ширхэг савыг байрлуулан хуримтлагдсан усаар нарийн ногоо, цэцгийнхүлэмж,таримал | | Хавсралт 2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | мод бутыг услах болон автомашины зогсоолын тоосжилтыг багасгахад ашиглаж байна. | | |
| Лаг хуримтлуулах талбай болон хатуу хог хаягдал хуримтлуулах талбайг цементлуулж,бетон болгох | 320.0 | - | Угаах цехээс гарсан лаг хуримтлуулах талбай болон хатуу хог хаягдал хуримтлуулах талбайг бетон болгосон. | **4,000,0** | Хавсралт 3 |
| Угаалгын бодисыг хадгалах тусгай зориулалтын жижиг оврын агуулахыг стандартын шаардлагад нийцүүлэх | - | - | Ноос, ноолуур угаах угаалгын шингэнийг хадгалдаг агуулахын дотоод зохион байгуулалт, зориулалтын өөрчлөн эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх өрөө гарган эм тарианы хайрцагийг байрлуулах, камерийн хяналттай болгох, агааржуулалтын хоолойг засварлах ажлуудыг хийж байна. | | Хавсралт 4 |
| Төслийн талбай орчмын иргэдийн санал хүсэлтийг харгалзан хорооны иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдэж өгөхөд туслөх | | | Эмээлтийн автобусны 32-р хорооны зогсоол буудлын албан ёсны зөвшөөрөл болон хурд сааруулагч байрлуулах хүсэлт, албан тоотыг ЗТГ, НЗХГазар,СХДүүргийн Засаг дарга болон хорооны Засаг дарга нарт тус тус албан бичгээр хүргүүлсэн.Төслийн талбай орчимд тулгамдаж байгаа төв замын үерийн далангийн цэвэрлэгээ, засвар, өргөтгөлийн асуудлаар 32-р хорооны Засаг даргад хүсэлт гаргасан.Дээрхи иргэд ажилчдаас ирүүлсэн санал хүсэлтийн шийдвэрлэлт удаашралтай байгаа. | | Хавсралт 5 |
| Газрын төлөв байдал,чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх | | | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг эрх бүхий “Тэнхлэг уул” ХХКомпаниар 2021 оны 04 сард гүйцэтгүүлсэн бөгөөд хүчинтэй байх хугацаа 2 жил. Харин 2023 онд газрын төлөв байдал,хөрс ургамал хамгаалалын шинжилгээг үйлдвэрийн гадна талбайн | | Хавсралт 6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 5 байршлаас хөрсний дээж авч Геологийн судалгаа – шинжилгээний төв ТӨҮГазарт шинжлүүлэхэд дээжээс тодорхойлсон элементүүд нь чанарын зөвшөөрөгдсөн хэмжээнд байгааг нь хариугаар баталгаажуулсан. | | |
| Нийт дүн,мян.төг | 940.0 | | | **4,400,0** | |
| **Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ** | | | | | |
| Газар, ус ашигласны болон бусад төлбөр | Жил | 5 | Дүүргийн хөгжлийг дэмжих, дүүргийн төсөвт хувь нэмэр оруулж газрын төлбөр,үл хөдлөх хөрөнгийн татвар, ус ашигласны төлбөр,ХАОАТатвар төлсөн. | Газрын төлбөрт– **19,479,6** ҮХХ татварт **-62,073,5** ХХОАТатварт **-50,518,6** УАТөлбөрт - - **4,140,0** | Хавсралт 7 |
| Ажлын байранд эмийн сан бий болгох | 5 | 10,0 | Ослын үед болон шаардлагатай үед ажилчдад цаг алдалгүй эмнэлгийн анхны тусламж үзүүлэх зорилгоор шинээр 5 ширхэг иж бүрэн эмийн санг уурын зуух,угаах, самнах болон ялгах цех, угаалгын шингэн хадгалдаг агуулахад байрлуулсан. | **500,0** | Хавсралт 8 |
| Төслийн үйл ажиллагаатай холбогдуулан дүүргийн болон хорооны холбогдох төр захиргааны байгууллагатай хамтран ажиллах | 1 | 100,0 | СХДүүргийн 32-р хорооны 0-2 насны хүүхдээ асарч чөлөөтэй байгаа 100 залуу эхчүүдэд эх үрсийн баяраар хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд идэвхтэй оролцож мөнгөн тусламж үзүүлсэн. | **500,0** | Хавсралт 9 |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж байх | Жил бүр | | 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын яамаар батлуулсан.Одоо 2023 оны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг гарган НБОГазарт хуулийн хугацаанд хүргүүлэн үнэлгээ авна.Мөн | | Хавсралт 10 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлж батлуулна. | | |
| Худагт тоолуур тавьж усны хэрэглээг тогтмол хянах | | | Усан сангийн технологи ажиллагаанд автоматжуулалт хийсэн.оффис, үйлдвэр, гал тогоо зэрэг нийт 3 байршилд байгальд ээлтэй, хялбархан, эдийн засгийн хэмнэлттэй мультионжуулагчийг авч суурьлуулсан.<br>Ионжуулагч төхөөрөмж нь 10 минутын хугацаанд бактерийг 99.9% арилгахаас гадна, усыг эрдэсээр минералжуулдаг бөгөөд энэ усыг хэрэглэснээр арьсны өвчин, үс уналт, өөх тосыг задлах зэрэг олон талт ач холбогдолтой юм. | **1,500,0** | Хавсралт 11 |
| Нийт дүн, мян.төг | 110.0 | | | **2,500,0** | |

## 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

| № | Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн зорилт | 2023 оны төлөвлөгөө | | Төлөвлөгөөний биелэлт | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **Нийт зардал, мян.төг** | **Тоо хэмжээ /5 жил/** | **Хийгдсэн ажил** | **Зарцуулсан хөрөнгө мян. төг** | **Баталгаажуулалт** |
| 1 | Үйлдвэрийн орчны тохижилт | 2,5 жилд нэг удаа | 100,0 | Авто машин явах зам талбайн урсгал,чиглэлийг заах тэмдэглэгээг хийсэн. | **100,0** | Хавсралт 12 |
| 2 | Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх /тэрбум мод хөтөлбөрийг дэмжин ажиллах / | Жил бүр | 200,0 | Оффисын хойд талын 3500 м2 талбайн зүлэгжүүлэлтийг “Мастер грийн” ХХК-иар гүйцэтгүүлж ногоон байгууламжийг бий болгосон.<br>Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд 2023 онд байгууллагынхаа хашаанд шинээр ягаан цэцэгт буйлс 10 ширхэг, улиас 15 ширхэг, хус 30 ширхэг, хайлаас 100 | **12,000,0** | Хавсралт 13 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ширхэг модлог бутыг нэмж тариалсан. | | |
| 3 | Цэцэг, нарийн ногоо тарьж ургуулах хүлэмж | | | 2023 оны 5 сард 6*10 хэмжээтэй хүлэмж барьж түүндээ улаан лооль, өргөст хэмх, амтат чинжүү, чинцай, сонгино, хаш өөрсдийн хүчээр үрэслүүлэн тарьж 7 сараас эхлэн ургацаа хураан авч хоолны газар тушаан ажилчдыг чанартай нарийн ногоогоор хангаж байна. | **1,950,0** | Хавсралт 14 |
| 2023 оны нийт зардал | | | 300,0 | | **14,050,0** | |

## 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

| № | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зорилт | 2023 оны төлөвлөгөө | | Төлөвлөгөөний биелэлт | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт зардал, мян.төг | Тоо хэмжээ /5 жил/ | Хийгдсэн ажил | Зарцуулсан хөрөнгө мян. төг | Баталгаажуулалт |
| 1 | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ | | | Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2023 оны 05 сард үйлдвэрийн ажлын байрны бичил цаг уур,гэрэлтүүлэг болон шуугианы түвшинг тодорхойлуулахаар ХХҮЕГазарт албан хүсэлт илгээсний дагуу физик хэмжилтийг улсын ахлах байцаагч хийж гүйцэтгэн 07/01-03/023/001 дүгнэлтийг гарган ирүүлсэн. Дүгнэлтэнд дурьдсан ажлын байранд шаардлагатай гэрэлтүүлэг болон харьцангуй чийгшлийг стандартад хүргэх ажлыг шийдвэрлэж ажиллалаа | | Хавсралт 15 |
| 2 | Эрсдлийн үнэлгээ хийх | | | Үйлдвэрийн захирал, инженер,ХАБ-ын ажилтан,мастеруудын бүрэлдэхүүнтэй ажлын комисс томилогдон самнах цехийн үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийж хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. | | Хавсралт 16 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Дотоод хяналт шалгалтхийх | | | ”Дотоод хяналтын журам”-ыг батлан мөрдүүлж, үйлдвэрийн үйл ажиллагаа, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээнд дотоод хяналтын ажилтан хяналт шалгалт хийж ажлын тайланг гарган, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах хугацаатай үүрэг даалгаврыг өгч,хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна | | Хавсралт 17 |
| 4 | Гэнэтийн ослын даатгалд даатгуулах | | | Ажилчдыг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Амар даатгал" ХХК-тай хамтран гэнэтийн ослын даатгалын гэрээг хийн эрсдэл бүхий ажлын байранд ажиллаж буй 48 ажилтанг даатгалд хамруулсан. | **768,0** | Хавсралт 18 |
| 5 | Эрүүл мэндийн хяналтын үзлэгт хамруулах | | | Ажилчдыг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Ундрах-Ирээдүй" Эрүүл мэндийн байгууллагатай хамтран нарийн мэргэжлийн эмчийн иж бүрэн үзлэгт нийт 75 ажилтан албан хаагчдыг хамруулан эрүүл мэндийн зөвөлгөө авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.. | **5,250,0** | Хавсралт 19 |
| 6 | Хоол үйлдвэрлэлийг баталгаатай хүнсний бүтээгдэхүүнээр хангах | | | Ажилчдын өдрийн хоол үйлдвэрлэлийн түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг “Номин”агуулахтай гэрээлэн барааны нэр төрөл бүрийг гарал үүслийн бичиг, шинжилгээний баталгаажилт, Ебаримттай худалдан авч байна. | | Хавсралт 20 |
| 2023 оны нийт зардал | | | 300,0 | | **6,018,0** | |

## 6. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | **2023 оны төлөвлөгөө** | **Төлөвлөгөөний биелэлт** |
|---|---|---|---|

| | | Нийт зардал, мян.төг | Тоо хэмжээ /5 жил/ | Хийгдсэн ажил | Зарцуулсан хөрөнгө мян. төг | Баталгаажуулалт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох | 250,0 | Жил бүр | Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, тусгай зориулалтын “Шил лааз”,”Хуванцар пластик”, “Бусад” гэсэн савнуудад байршуулж хэвшсэн. | **1,500,0** | Хавсралт 21 |
| | | 250,0 | Жил бүр | СХДүүргийн "Экоэринтохижилт" ХХК болон СХДүүргийн татварын албатай хийсэнгурвалсан гэрээг хийжцугларсан хатуу хог хаягдлыг тээврийн хэрэгслэлээр зөөвөрлөн нэгдсэн цэгт хүргэж устгадаг. | | Хавсралт 22 |
| | | 250,0 | Жил бүр | Хатуу хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтайг сонгон, хогийн цэгт байршуулан ашиглаж байна. | | Хавсралт 23 |
| 2 | Шингэн хог хаягдлаар хөрс,газар доорх ус бохирдож болзошгүй | 750.0 | Жил бүр | Шингэн хог хаягдлын бохир ус хадгалах танкинд хуримтлуулж тусгай зөвшөөрөлтэй “Говийн марз” ХХК, “Грийнфантом” ХХК-тай хийсэн гэрээний дагуу зориулалтын тээврийн хэрэгслэлээр зөөвөрлөн цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг. | **6,500,0** | Хавсралт 24 |
| Нийт дүн | | 1500.0 | | | **8,000,0** | |

**7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

| № | Төлөвлөсөнаргахэмжээ | Урьдчилан тооцсонтөсөв | Хэрэгжүүлэххуваарь | | Хийгдсэн ажил | Зарцуулсан хөрөнгө мян. төг | Баталгаажуулалт |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2023 он | | | | |
| | | | Сар7 | Сар 11 | | | |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ноос, ноолуур бэлтгэгч нөхөрлөл хоршоодын гишүүдийн уулзалт, сургалт | | + | | Бэлтгэн нийлүүлэгч “Уран арвижих” хоршооны гишүүд тус үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцан ноос,ноолуурын борлуулалтаа ебаримтын апплекейшн ашиглан шивэлт хийх хялбар аргыг сурталчлан таниуллаа. | **500,0** | Хавсралт 25 |
| | Нийт | | | | | | |

**8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт**

| **№** | **БОМТ, БОМТний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд** | **Тайлагнах хэлбэр** | **Мэдээллийнаг уулга** | **Зохионбайгуу лаххугацааны тов** | **Тайлагнах зардал, төг** | **Зохионбайгуулахгазар** | **Баталгаажуул алт** |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** | **7** |
| 1 | СХДүүргийн 32-р хорооны Засаг дарга, иргэдийн нийтийн хурлын дарга,зохион байгуулагчид болон оршин суугчид | PPT | 2023 оны менежментийн төлөвлөгөөний биелэлт | 2023.09.20 | **100,0** | Сонгинохайрхан дүүргийн 32 -р хорооны Иргэдийн танхим | Хавсралт 26 |
| | Нийт | | | | | | |
| | | | | | | | |

**Хавсралт 1**



Батлав: "Санитар төв" ХХК
Захирал Б.Түвшинтөгс

"........................................" ХХК
Захирал

**Мал эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлт хийх гэрээ № ......01/23.**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Энэхүү гэрээ нь Монгол улсын нутаг дэвсгэрт мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ үйл ажиллагаа явуулж буй ААНэгж, иргэдийн ажлын байр, түүний орчин, түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлэгийн ариутгал халдваргүйжүүлэлт хийхэд гэрээний зорилго оршино.

1.2 Энэ гэрээгээр нэг талаас мал эмнэлэг, ариутгал халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий "Санитар төв" ХХК, /цаашид мал эмнэлэг гэх/ нөгөө талаас малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй ААН, иргэн хоорондын үйл ажиллагааг зохицуулна.

**Хоёр. Мал эмнэлгийн хүлээх эрх, үүрэг**

2.1 Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, ажлын байр, орчины ариутгал халдваргүйжүүлэлтийг улирал бүр хийнэ. Шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй хийнэ.

2.2 Ариутгал халдваргүйжүүлэлтийг зөвшөөрөгдсөн эмийн бодис ашиглан, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

2.3 Ариутгал халдваргүйжүүлэлт хийж гүйцэтгэж буй явцыг видео хийж баримтжуулан, зураг авч, актыг 2% үйлдэж, нэг хувийг ААН, иргэнд өгнө.

2.4 Харилцагч аж ахуйн нэгж иргэдийг үйл ажиллагаатай нь холбоотой мэдээлэл, заавар удирдамжаар хангах, тэдэнд аль болох чирэгдэл учруулахгүйгээр түргэн шуурхай үйлчилгээ үзүүлнэ.

2.5 Ариутгал халдваргүйжүүлэлт хийх тухай 24 цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

**Гурав. ААН, иргэдийн хүлээх эрх, үүрэг**

3.1 Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, ажлын байр, орчины ариутгал халдваргүйжүүлэлтийг улирал бүр хийлгэнэ Шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй хийлгэнэ.



**Хавсралт 2**



**Хавсралт 3**






**Хавсралт 4**






**Хавсралт 5**



НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАРТ

ХАТАНТ ИНТЕРНЭШНЛ ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг
32-р хороо, 1-124 тоот
E mail: khatant.int@gmail.com, Утас: (976)-75958888

2023.06.16 № 23/81

Танай__________-ны №__________-т

Хүсэлт гаргах тухай

“Хатант интернэшнл” ХХКомпани нь ноос ноолуур боловсруулах анхан шатны үйлдвэрлэл эрхэлдэг бөгөөд СХДүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт байрлан үйл ажиллагаа явуулан даруй 7 жил болж байна.. Өнгөрсөн хугацаанд тус компаны хойд талын баруун чиглэлийн төв зам дээр хурд хэтрүүлснээс хүний амь нас хохирох, гэмтэж, бэртэх, тээврийн хэрэгсэл мөргөлдөх зэрэг зам тээврийн ноцтой ослууд олон удаа гарсаар байна.

Дээрх автын ослууд гарч буй шалтгаан нь

- Замын нөхцөл байдал уруу, машинууд маш их хурдтай орж ирдэг
- Автобусны буудал нь албан ёсоор баталгаажаагүй тул автобусны жолооч нар дурын газраа зогсож зорчигчдоо суулгаж, буулгадаг. Тухайлбал: 32-р хороо руу эргэх уулзвар болон тус компаны орох, гарах хаалга, пүүний харалдаа байнга зогсдог.
- Зам дээр хурд сааруулагчгүй, гэрэлтүүлэггүй, явган зорчигчийн гарц, бусад замын тэмдэг, тэмдэглэгээ байхгүй байгаатай холбоотой юм.

Иймд Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны оршин суугчид болон тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдын аюулгүй зорчих нөхцлийг хангах үүднээс баруун чиглэлийн төв зам дээрх автобусны буудлын зогсоолыг яаралтай тодорхой болгож, нэн даруй зайлшгүй шаардлагатай хурд сааруулагч, явган хүний гарц, гарам, гэрэлтүүлэг, тэмдэг тэмдэглэгээг хийх тал дээр холбогдох байгууллагуудад уламжлан хамтран ажиллан туслалцаа үзүүлнэ үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ГАНБАТ



СХД-ИЙН 32-Р ХОРООНЫ ЗАСАГ ДАРГА С.УЯНГА ТАНАА

ХАТАНТ ИНТЕРНЭШНЛ ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг
32-р хороо, 1-124 тоот
E mail: khatant.int@gmail.com, Утас: (976)-75958888

2023.06.02 № А-23/77.

Танай__________-ны №__________-т

Хүсэлт гаргах тухай

“Хатант интернэшнл” ХХКомпани нь ноос ноолуур боловсруулах анхан шатны үйлдвэрлэл эрхэлдэг бөгөөд СХДүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт байрлан үйл ажиллагаа явуулан даруй 7 жил болж байна.. Өнгөрсөн хугацаанд тус компаны хойд талын баруун чиглэлийн төв зам дээр хурд хэтрүүлснээс хүний амь нас хохирох, гэмтэж, бэртэх, тээврийн хэрэгсэл мөргөлдөх зэрэг зам тээврийн ноцтой ослууд олон удаа гарсаар байна.

Дээрх автын ослууд гарч буй шалтгаан нь

- Замын нөхцөл байдал уруу, машинууд маш их хурдтай орж ирдэг
- Автобусны буудал нь албан ёсоор баталгаажаагүй тул автобусны жолооч нар дурын газраа зогсож зорчигчдоо суулгаж, буулгадаг. Тухайлбал: 32-р хороо руу эргэх уулзвар болон тус компаны орох, гарах хаалга, пүүний харалдаа байнга зогсдог.
- Зам дээр хурд сааруулагчгүй, гэрэлтүүлэггүй, явган зорчигчийн гарц, бусад замын тэмдэг, тэмдэглэгээ байхгүй байгаатай холбоотой юм.

Иймд СХДүүргийн 32-р хорооны оршин суугчид болон тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдын аюулгүй зорчих нөхцлийг хангах үүднээс баруун чиглэлийн төв зам дээрх автобусны буудлын зогсоолыг яаралтай тодорхой болгож, нэн даруй зайлшгүй шаардлагатай хурд

**Хавсралт 6**



Маяг ХФ-01

ГСШТ-ийн захирлын 2023 оны А/03 тушаалын 1-р хавсралт

ГЕОЛОГИЙН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

ГЕОЛОГИЙН СУДАЛГАА-ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ ТӨҮГ

**ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

**Захиалгын дугаар: ХФ 2023/0475**

**Захиалагчийн нэр: Хатант Интернэшнл Х**

| № | Лаб № | Дээж № | Дээжийн тодорхойлолт | Элемент, мг/кг | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | As | Ba | Bi | Cd | Ce | Co | Cr* | Cu | La | Li | Mn | Mo | Ni | P | Pb | Rl |
| 1 | 2593 | 1 | - | 20.06 | 577 | <10 | <5 | 58.38 | 10.88 | 34.93 | 15.62 | 30.72 | 27.96 | 469 | <5 | 19.74 | 623 | 13.36 | 10 |
| 2 | 2594 | 2 | - | 19.57 | 554 | <10 | <5 | 50.54 | 9.35 | 29.43 | 10.58 | 26.46 | 26.07 | 408 | <5 | 16.25 | 601 | 11.86 | 10 |
| 3 | 2595 | 3 | - | 15.03 | 585 | <10 | <5 | 52.73 | 10.82 | 26.76 | 12.26 | 27.83 | 26.58 | 441 | <5 | 17.30 | 586 | 11.15 | 12 |
| Чанарын хяналт | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | АСЗ | Шифр-2523 | Аттестатчилсан утга | - | 657 | 0.32 | 0.13 | 67.84 | 14.01 | 68.88 | 29.40 | 34.00 | 23.00 | 798 | 1.11 | 31.55 | 672 | 17.26 | 80.4 |
| | | | Шинжилсэн утга | 12.93 | 633 | <10 | <5 | 63.86 | 15.75 | 64.44 | 23.78 | 29.44 | 23.25 | 629 | <5 | 30.93 | 709 | 10.76 | 73.9 |
| Шинжилгээний аргын код | | | | ICP-17 | | | | | | | | | | | | | | | |

| № | Лаб № | Дээж № | Дээжийн тодорхойлолт | Элемент, мг/кг | | | | | | | | Элемент, % | | | | | | pH |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Sb | Sn* | Sr | Ti | V | W* | Zn | Zr | Al | Ca | Mg | Na | K | Fe | |
| 1 | 2593 | 1 | - | <10 | <10 | 338 | 3484 | 57.58 | <10 | 69.50 | 70.39 | 6.86 | 2.25 | 0.81 | 2.01 | 2.18 | 3.16 | 8.38 |
| 2 | 2594 | 2 | - | <10 | <10 | 299 | 3216 | 54.43 | <10 | 60.08 | 65.63 | 6.78 | 1.85 | 0.72 | 2.10 | 2.10 | 2.91 | 8.43 |
| 3 | 2595 | 3 | - | <10 | <10 | 314 | 3543 | 58.17 | <10 | 63.58 | 74.89 | 7.07 | 2.02 | 0.77 | 2.12 | 2.26 | 2.93 | 8.46 |
| Чанарын хяналт | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | АСЗ | Шифр-2523 | Аттестатчилсан утга | 1.10 | 2.60 | 387 | 5216 | 97.00 | 1.40 | 74.67 | - | 7.76 | 1.78 | 0.92 | 2.27 | 2.07 | 3.95 | 7.00 |
| | | | Шинжилсэн утга | <10 | <10 | 379 | 4805 | 83.18 | <10 | 70.61 | 78.08 | 7.16 | 1.71 | 0.85 | 1.99 | 1.88 | 3.83 | 7.47 |
| Шинжилгээний аргын код | | | | ICP-17 | | | | | | | | | | | | | | УсШ-102 |

Гүйцэтгэсэн инженер: Б.Ангирмаа, С.Ундраа
(нэр)

Хэвлэсэн огноо: 5/17/2023

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ... ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL 02

## Хавсралт 7



Татварын ерөнхий газрын даргын 2019 оны 08 сарын 30-ны өдрийн А/146 дугаар тушаалын 6-р хавсралт

**МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА**

**СХД 32 хороо-т**

**Аж ахуй нэгж, байгууллагын тодорхойлолт**

Дугаар 23.1003.2753dcc8-6809-4705-ab6d-b7993ecb017b

*Татвар төлөгчийн нэр :* *Хатанит-Интернэшнл*

*Татвар төлөгчийн дугаар :* *2706442*

*Хариуцлагын хэлбэр :* *Хязгаарлагдмал хариуцлагатай компани*

*Хаяг байршил :* *Улаанбаатар, Чингэлтэй, 4-р хороо, null*

*Удирдлагын овог, нэр :* *Дагваажанцан Ганбат*

*Байгуулагдсан огноо :* *2006-09-19 03:00:00*

*Тодорхойлолтын зориулалт :* *Тодорхойлолт*

*Тодорхойлолтын хамаарах он :* *2023*

**Татварын тайлан тушаалт**

| Тайлант хугацаа | Тайлан ирүүлбэл зохих хугацаа | Тайлан ирүүлсэн эсэх | Тайлангийн хэлбэр |
|---|---|---|---|

**Цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байдал**

| Холбогдсон эсэх | Холбогдсон огноо | Баримт илгээсэн хэлбэр | Сүүлд хэвлэсэн баримтын огноо |
|---|---|---|---|
| ТИЙМ | 2016-02-18 22:40:24 | Сард 10-аас бага | 2023-07-31 23:59:59 |

**Татвар төлөлт**

| Хугацаа | Тайлангийн төрөл | Татварын төрөл | Төлсөн дүн |
|---|---|---|---|
| | Улирал | Баянгол - Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар | 50,518,553.15 |
| | Жил | Баянгол - Зам ашигласны төлбөр | 60,000.00 |
| | Жил | Баянгол - Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 6,000.00 |
| | Жил | Баянгол - Агтын агаарын бохирдлын төлбөр | 9,500.00 |
| | Улирал | Сонгинохайрхан - Хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 62,073,575.00 |
| | Улирал | Сонгинохайрхан - Газрын төлбөр-Дэд алба | 14,263,349.00 |
| | Улирал | Том татвар төлөгчийн газар - Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 50,446,161.88 |
| | Улирал | Том татвар төлөгчийн газар - Ус бохирдуулсны төлбөр | 4,140,600.00 |
| | Улирал | Хан-Уул - Газрын төлбөр-Дэд алба | 5,215,824.00 |
| Нийт | | | 186,733,563.03 |

**Татварын тооцооллын үлдэгдэл**

23.1003.2753dcc8-6809-4705-ab6d-b7993ecb017b

**Санамж**

Тодорхойлолтыг шалгахдаа QR кодыг ашиглан Татварын албаны цахим хуудсаар дамжуулан шалгах боломжтой. Энэхүү тодорхойлолтыг хуурамчаар үйлдэхийг хориглоно. Хэрэв хуурамчаар үйлдсэн тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

Үүсгэсэн огноо 2023-10-02 12:12:22

Хүчинтэй огноо 2023-11-02 12:12:22

1

**Хавсралт 8**






**Хавсралт 9**



БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА Б. БУЯННЭМЭХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"ХАТАНТ-ИНТЕРНЭШНЛ" ХХК
ЗАХИРАЛ Б.БАЯРМАА

"ХАТАНТ-ИНТЕРНЭШНЛ" ХХК НИЙ УЛААНБААТАР ХОТ, СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ, 32-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИНЭ.ХАТАНТ КАШМЕР "НООС НООЛУУР УГААХ, САМНАХ ҮЙЛДВЭР" ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2708442

ХЯНАСАН:
ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН ПҮРЭВ. ШИНЭЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:
"ХАТАНТ-ИНТЕРНЭШНЛ" ХХК
БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭРГЭЖИЛТЭН Б.ОЮУНТУЯА

2023 ОН

**Хавсралт 10**


Мультионжуулагч
БАЙГАЛД ЭЭЛТЭЙ
Зэв, хлор агуулагдсан усыг хамгийн жижиг, макро элемент болтол задлан усыг цэвэршүүлнэ
ШИНЭЧЛЭЛ
Ионжсон, өвчин үүсгэгч нян бактерийг устгах чадвартай, угаах ариутгах чадвартай, үнэрийг дарах чадвартай
GEMMOVE
MULTIIONIZER
MADE IN KOREA
ЭДИЙН ЗАСАГТ ХЭМНЭЛТТЭЙ
Фильтр солих шаардлагагүй, усаа гамнана, саван, нунтаг огт хэрэггүй
ХЯЛБАРХАН
Угсрахад амархан, нэмэлт цахилгаан хэрэглэх шаардлагагүй
GEMMOVE



**Хавсралт 11**





**Хавсралт 12**





**Хавсралт 13**



**Хавсралт 14**





**Хавсралт 15**

ХАТАНТ
Интернэшнл ХХК

ХӨДӨЛМӨР ХАЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЕРӨНХИЙ ГАЗАРТ


ХАТАНТ ИНТЕРНЭШНЛ ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг
32-р хороо, 1-124 тоот
E mail: khatant.int@gmail.com, Утас: (976)-75958888


2023.5.11 № 23/54

Танай ______ -ны № ______ -т

Хүсэлт гаргах тухай

"Хатант Интернешнл" ХХК нь анхан шатны боловсруулах үйлдвэр бөгөөд 2023 оны үйлдвэрийн үйл ажиллагаагаа эхэлсэнтэй холбогдуулан үйлдвэрийн орчны тоосжилт, дуу чимээ, гэрэлтүүлэг зэрэг орчны шинжилгээг хийлгэх хүсэлтэй байгаа тул хүлээн авч шийдвэрлэнэ үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.Ганбат Д.ГАНБАТ

"ХАТАНТ ИНТЕРНЭШНЛ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ГАНБАТ
ТАНАА


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ
Чингисийн өргөн чөлөө, 2 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17042
Утас/Факс: (976) 7014 7019,
Цахим шуудан: info@hudulmur-halamj.gov.mn,
Цахим хуудас: www.hudulmur-halamj.gov.mn


2023.06.02 № 07/01-03/023/001.

Хэмжилт хийсэн тухай

Танай байгууллагаас албан тоотоор ирүүлсэн хүсэлтийн дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 07/01/001 дугаартай "Төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай" удирдамжийн дагуу Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд байрлах ноос, ноолуур боловсруулах анхан шатны үйлдвэрийн ажлын байрны бичил цаг уур, гэрэлтүүлэг, шуугианы түвшинг тодорхойлох зорилгоор фикик хэмжилтийг 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдөр үйлдвэр хариуцсан захирал Б.Батцэцэгийг байлцуулан хийлээ.

Хөдөлмөрийн эрүүл ахуйн физик хэмжилтийг CEM DT-625 маркийн Thermometer Humidity Meter, YH-610 Environment Multimeter, TES 1350A багажаар хийж гүйцэтгэсэн.

Үйлдвэрийн ажлын байранд хийсэн хэмжилтийн дүнг хүснэгтээр гаргавал:

| № | Хэмжилт хийсэн ажлын байрны нэр | Агаарын хэм | Харьцангуй чийгшил | Гэрэлтүүлэг | Шуугиан |
|---|---|---|---|---|---|
| | Самнах цех | | | | |
| 1 | Самнах 8 дугаарын машины дэргэд | 20.1 | 51.1 | 490 | 70 |
| 2 | Самнах 1 дугаарын машины дэргэд | 19.4 | 54 | 590 | 69 |
| 3 | Самнах 3 дугаарын машины дэргэд | 21.5 | 52 | 450 | 67 |
| 4 | Самнах цехийн гол хэсэгт | 21.6 | 53 | 380 | 68 |
| 5 | Хялгас ялгах машины дэргэд | 21.5 | 52.3 | 180 | 67 |
| 6 | Сэгсрэх машины дэргэд | 20.1 | 50.4 | 180 | 70 |
| | Угаах цех | | | | |
| 7 | Угаах машины 1 дүгээр шугамын орох хэсэг | 23.0 | 30 | 380 | 64 |
| 8 | Угаах машины онгоцны дэргэд | 23.9 | 32 | 400 | 66 |
| 9 | Угаах цехийн голын хэсэгт | 23.5 | 35 | 370 | 62 |
| 10 | Преслэх машины дэргэд | 22.0 | 30 | 480 | 65 |
| | Уурын зуухны хэсэгт | | | | |
| 11 | Уурын зуухны нүүрсний амсар хэсэгт | 21 | 22.5 | 131 | 79.8 |
| 12 | Уурын зуухны ажлын байрны голын хэсэгт | 20.4 | 23.0 | 114 | 79 |
| | **Эрүүл ахуйн зөвшөөрөх хэмжээ** | **Дунд–IIa 18-27° C** | **30-60 хувь** | **300 люкс-ээс дээш** | **85 дБА** |

07110?

**Хавсралт 18**

АМАР ДААТГАЛ ®

Даатгалын гэрээний №: 88С2300448
Даатгуулагч: "ХАТАНТ ИНТЕРНЭШНЛ" ХХК

## ДААТГАЛЫН ГЭРЭЭ

*Та гэрээний нэг тал тул анхааралтай уншиж танилцана уу.*

Гэрээний дугаар: 88С2300448

**АМАР ДААТГАЛ ХХК**
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө гудамж, Блю скай тауэр, 20 давхар
Утас: 18002111
И-мэйл: info@amardaatgal.mn
Вэб хуудас: www.amardaatgal.mn

Хуудас | 1

---

**ХААН БАНК**

Огноо/Date: 2023.08.31 12:39:57

## Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

**Журналын/Journal No: 2456862**

**Системийн огноо/System Date: 2023.08.25 08:50:07**

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Дт/From** | **Дансны/Картын дугаар Account/Card number** 5030161057 | **Нэр/Name** ХАТАНТ ИНТЕРНЭШНЛ ХХК | **Дүн/Amount** 768,000.00 MNT | **Ханш/Rate** 1.00 |
| **/ Долоон зуун жаран найман мянган төгрөг /** | | | | |
| **Кт/To** | **Банкны дугаар/Branch No** 05<br>**Дансны/Картын дугаар Account/Card number** 5220059399 | **Банкны нэр Bank Name** Хаан банк<br>**Нэр/Name** АМАР ДААТГАЛ | 768,000.00 MNT | 1.00 |

**Гүйлгээний утга/Transaction description:**
**ЕВ-хатант интернэшнл ххк даатгалын хураамж**

**Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers**

**Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:**

**Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:**

**Гарын үсэг/Signature:**

**Тамга/Stamp:**

______ **Он/Year (YYYY)** ______ **Сар/Month (MM)** ______ **Өдөр/Day (DD)**

**Хавсралт 19**





**Хавсралт 20**

ISO 45001: 8.1.4.1

## ДАРАА ТООЦООГООР ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2023 оны 10-р сарын 18-ны өдөр Дугаар: ТЕВ/23/2465 23/17 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг

Нэг талаас: Монгол Улсын хуулийн этгээд болох **"Номин Хайпермаркет" ХХК** (Регистр: 6736076), түүнийг төлөөлж Итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Жаргалсайхан *(цаашид "Нийлүүлэгч" гэх)*,

Нөгөө талаас: Монгол Улсын хуулийн этгээд болох **"Хатант интернешнл" ХХК** (регистр:2708442), түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Дагважанцан овогтой Ганбат*(цаашид "Худалдан авагч" гэх)*

нар *(тус тусад нь "Тал" гэх, хамтад нь "Талууд" гэх)* гэрээний дор дурьдсан гол болон стандарт нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

### 1. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ

1.1. Энэхүү гэрээгээр Нийлүүлэгч нь Худалдан авагчийн захиалгын дагуу захиалгад заагдсан нэр төрөл, үзүүлэлт, тоо хэмжээ бүхий бараа бүтээгдэхүүн */цаашид "Бараа материал" гэх/*-ийг Худалдан авагчид урьдчилан танилцуулах үнийн саналд заагдсан үнээр нийлүүлэх, Худалдан авагч нь хүлээн авсан бараа материалын төлбөрийг гэрээний гол нөхцөлд заасны дагуу төлөхтэй харилцааг зохицуулна.

1.2. Талууд энэхүү гэрээний дагуу ажиллахдаа Монгол Улсын хууль тогтоомжийг дээдлэн, гэрээний Гол нөхцөл болон Стандарт нөхцөлийн заалт бүрийг дагаж мөрдөнө. Гэрээгээр зохицуулагдаагүй бусад харилцааг талууд холбогдох хуульд заасны дагуу зохицуулна.

1.3. Гэрээний гол нөхцөл болон стандарт нөхцөлийн заалтууд хоорондоо зөрчилдвөл Гол нөхцөлийн заалтыг удирдлага болгоно.

<u>Гэрээний үндсэн нөхцөлүүд</u>:

| | | |
|---|---|---|
| 1.4. | Гэрээний хугацаа: | 1.4.1. Энэхүү гэрээ нь 2023 оны 10 сарын 18 ны өдрөөс 2024 он 10 сарын 18 ны өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.<br>1.4.2. Гэрээний хугацаа дуусахад үргэлжлүүлэн сунгах эсэхийг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ. |
| 1.5. | Бараа материалын захиалга хүлээн авах: | 1.5.1. Нийлүүлэгч нь Худалдан авагчаас бараа материалын захиалгыг дор дурдсан цахим шуудангаар хүлээн авна.<br>- Нийлүүлэгчийн захиалга хүлээн авах и-мэйл хаяг: byerikbol.b@nomin.net<br>- Худалдан авагчийн захилга өгөх и-мэйл хаяг: Bayartsengel8889@gmail.com |
| 1.6 | Бараа материал нийлүүлэх хугацаа: | 1.6.1. Захиалга хүлээн авснаас хойш хуанлийн 3 хоногийн дотор |
| 1.7 | Бараа материалын тээвэрлэлт: | 1.7.1. Нийлүүлэгч тал нь Худалдан авагчийн захиалсан бараа материалыг Худалдан авагчийн заасан газарт өөрийн унаагаар хүргэж, хүлээлгэн өгнө.<br>- Худалдан авагч нь захиалсан бараа бүтээгдэхүүнийг Нийлүүлэгчийн салбар нэгжээс очиж хүлээн авна. |
| 1.8 | Үнэ, төлбөрийн нөхцөл: | 1.8.1. Нийлүүлэгч тал энэхүү гэрээ байгуулагдсаны дараа захиалга хүлээн авахаас өмнө бараа материалын нэгж үнийг тодорхойлсон үнийн саналыг Худалдан авагчид хүргүүлэх ба нэгж үнэ өөрчлөгдөх тухай бүрт шинэчлэгдсэн үнийн саналыг Худалдан авагч талд хүргүүлнэ. Бараа материалын нэгж үнэнд НӨАТ болон барааг үйлдвэрлэх тээвэрлэх баглаа боодлын үнэ багтсан байна.<br>1.8.2. Худалдан авагч тал үнийн саналыг хүлээн авсан нотлох баримтыг үйлдэж нийлүүлэгчид илгээж байна.<br>1.8.3. Нийлүүлэгчийн үнийн санал нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болох бөгөөд нийлүүлсэн бараа материалын үнэ, төлбөрийг тооцох гол нөхцөл болно.<br>1.8.4. Худалдан авагч тал хүлээн авсан бараа материалын төлбөрийг бараа хүлээн авсанаас хойш тухайн сарын сүүлийн долоо хоногт багтаан гэрээний гол нөхцөлд заасан нийлүүлэгчийн харилцах дансанд бүрэн төлж барагдуулна. |



| | | |
|---|---|---|
| 1.9 | Тооцоо нийлэх: | 1.9.1. Талууд сар бүрийн эхний долоо хоногт тооцоо нийлж төлбөрийн үлдэгдэлийг баталгаажуулж явна.<br>1.9.2 Талуудын төлөөлөл болсон дараах ажилтнууд сар бүр тооцоо нийлнэ. Ажилтнуудын мэдээлэл.<br>Нийлүүлэгч талаас: З.Одбилэг /Эдийн засагч, ахлах нягтлан бодогч /<br>Худалдан авагч тал: С.Отгонжаргал /Нягтлан бодогч / |
| 1.10 | Нийлүүлэгч талын төлбөр хүлээн авах данс | Хаан банк: 5038110628 тоот данс.<br>Голомт банк: 2715145337 тоот данс. |
| 1.11 | Баталгаат хугацаа: | Бараа бүтээгдэхүүний баталгаат хугацаа сайтан дээр тавигдсан байдаг. |
| 1.12 | Алданги: | 1.12.1. Нийлүүлэгч тал гэрээний гол нөхцөлд заасан бараа материал нийлүүлэх хугацааг хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх хэмжээгээр Худалдан авагч талд алданги төлнө.<br>1.12.2. Худалдан авагч тал гэрээний гол нөхцөлд заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх хэмжээгээр Нийлүүлэгч талд алданги төлнө. |
| 1.13 | Хавсралт: | Байхгүй |
| 1.14 | Бараа материалын доголдол: | Нийлүүлэгч нь биет байдлын доголдолтой бараа бүтээгдэхүүнийг мэдсэн. Худалдан авагч гомдол гаргаснаас хойш 7 хоног дотроо багтаан өөр доголдолгүй өөр бараа бүтээгдэхүүнээр солих үүрэг хүлээнэ. |
| 1.15 | Талуудыг төлөөлөх эрх бүхий ажилтан: | Талууд өөрийн компанийг төлөөлөх эрх бүхий ажилтны мэдээллийг нөгөө талдаа бичгээр өгч баталгаажуулна. |

### ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛИЙГ ЗӨВШӨӨРЧ, ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**Нийлүүлэгч талыг төлөөлж:**

"Номин Хайпермаркет" ХХК

Нэр: Д. Жаргалсайхан
Албан тушаал: Итгэмжлэгдсэн төлөөлөгч

Гарын үсэг: ______

Нэр: Б. Берикбол
Албан тушаал: Үйл ажиллагааны менежер

Гарын үсэг: ______

Хаяг: Номин Юнайтед оффис Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Улаанбаатар 17042, Монгол Улс
Утас: 1800 2888, Факс: 976 75778888

**Худалдан авагч талыг төлөөлж:**

"Хатант интернешнл" ХХК

Нэр: Д.Ганбат
Албан тушаал: Гүйцэтгэх захирал
Гарын үсэг: ______

Нэр: Б.Баярсэнгэл
Албан тушаал: Нярав

Гарын үсэг: ______

Хаяг: СХД 32-р хороо хайрханы 1-24

**Хавсралт 22**

**БАТЛАВ:** **БАТЛАВ:**

**"ГРИЙН ФАНТОМ" ХХК**

**ЗАХИРАЛ** Баттулга **Б. БАТТУЛГА** **ЗАХИРАЛ**

**ХЭРЭГЛЭЭНЭЭС ГАРСАН БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ**

2023 он 4-р сарын 20 өдөр № 2/004 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Хатант Интерпошнл ХХК /цаашид Захиалагч тал гэх/ түүнийг төлөөлж Э. Галбат..., нөгөө талаас "Грийн фантом" ХХК /цаашид гүйцэтгэгч тал гэх/ түүнийг төлөөлж захирал Б. Баттулга нар нь доорхи нөхцлөөр харилцан тохиролцож зөвшөөрснөөр байгуулав.

**Нэг. Нийтлэг заалт**

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь Захиалагч талын өмчлөлийн объектын бохир усыг өөрийн ажиллах хүч, техникч тоног төхөөрөмжөө ашиглан тээвэрлэх, захиалагч тал нь тухайн ажилд нь тохирсон хөлс төлөх болон талуудын эрх үүргийн харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү гэрээний хугацаа 2023 оны 4... сарын 20.-ны өдрөөс 2024 оны 4. сарын 20..... – ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.3 Талууд гэрээний хугацаа дуусгавар болоход гэрээг цуцлах санал гараагүй тохиолдолд гэрээг ижил нөхцөл хугацаатайгаар дахин сунгагдсанд тооцно.

**Хоёр. Төлбөр тооцоо, түүнийг төлөх үндэслэл**

2.1 Хоёр тал харилцан тохиролцсоноор үйлчилгээний ажлын нэг удаагийн тээвэрлэлтийн үнэ нь дор дурдсанаар байх бөгөөд уг үнэд НӨАТ орсон болно.

2.1.1 ..... тн машин рейс нь ........1м3 (.......6000 НӨАТ-тэй.......... ) төгрөг болно.

2.2 Захиалагч талын санал болгосон тонны автомашинаар гүйцэтгэгч тал нь тээвэрлэлтийг хийх бөгөөд захиалагч тал нь үнийг шилжүүлэхдээ энэхүү гэрээний 2.1 дэх заалтыг удиртгал болгон нэхэмжлэхийн дагуу төлнө.

**Гурав. Захиалагчийн эрх үүрэг**

3.1 Үйлчилгээний дуудлагыг тухайн бохир ус тээвэрлэлт хийлгэх өдрийн урд өдөр 09.00-18.00 цагийн хооронд үйлчилгээ гүйцэтгэгчид өгсөн байна. Хэрэв тухайн заасан цагт дуудлага өгөөгүй бол дуудлага дараа өдрийн дуудлагад орох болно.

3.2 Бохир ус сорох явцад хяналт тавьж дутуу сорсон тухай бүр үйлчилгээг гүйцэтгэгчид мэдэгдэж шаардлага тавьж доголдол арилгах хугацаар тогтоон гүйцэтгэгч талын зардлаар дахин гүйцэтгүүлэх.

3.3 Гүйцэтгэгч талтай тохирсоны дагуу аливаа хөнгөлөлтийг нэмэлт нөхцөлд заасны дагуу эдлэх

Зайлшгүй шаардлагатай нэмэлт ажил /шугам бөглөрөх, лайдах, дулаалах г.м/ гарвал үйлчилгээг гүйцэтгэгчтэй тухайлан харилцан тохиролцсоны дагуу үйлчилгээг хийлгүүлэх.

3.5 Ажлын хөлсийг нэхэмжилснээс хойш ажлын 5 /тав/ өдөрт багтаан төлөхгүй тохиолдолд хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.5 %-тай тэнцэх хэмжээний алдангийг захиалагч нь гүйцэтгэгчид төлөх.

**Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх үүрэг**

---

Батлав

"ГОВИЙН МАРЗ ХАЙРХАН" ХХК

Захирал Т.Мөнх-Эрдэнэ

/.............................../

Утас:89168473

Батлав

Хатант Интерпошнл ХХК-ний

Захирал.............................

/.........Н. Жамъян...................../

Утас: 99091988, 99142491.

**Хамтран ажиллах гэрээ**

**Улаанбаатар хот** 2023 оны 4...-р сарын 4..-ны өдөр

Нэг талаас ажил гүйцэтгэгч **"ГОВИЙН МАРЗ ХАЙРХАН" ХХК**, нөгөө талаас цаашид ........................................................................................................................ Захиалагч гэх нар харилцан тохиролцож хамтран ажиллахаар Монгол улсын иргэний хууль, байгаль хамгаалах хууль түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг удирдлага болгон дараах гэрээг байгуулав.

**Нэг. Нийтлэг заалт**

Энэхүү гэрээний зорилго нь

......Ахуйн үйлдвэрийн бохир усыг........................................................................

Бохир усны савнаас бохирын машинаар сорон уг цогцолбороос ............ км зайд тээвэрлэн зориулалтын шугамны бохир усны худагт тээвэрлэн хийнэ. 2023 оны 4.. сарын 4.. 2024 оны 4. сарын 4 хүртэл тээвэрлэнэ.

**Хоёр. Төлбөр тооцоо**

Бохир ус зайлуулах нэг рейсийн үнэ......1м3 6000 НӨАТ-тэй.........төгрөг байна............................уг үнэнд гүйцэтгэгч талын бүх зардлууд багтсан болно.Тухайн албан тушаалтан хариуцан рейсийн тоог бүртгэж замын хуудас бөглөнө.Төлбөрийн тооцоог замын хуудас үндэслэн бэлнээр болон дансаар олгоно. **/ Голомт банк: 1415109607 /**

**Гурав. Захиалагчийн эрх үүрэг**

- ✓ Ажил үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотой бүх мэдээлэл, анхааруулга, зааварчилгаа санамжуудыг өгч, холбогдох нөхцлийг бүрэн хангана
- ✓ Ажлын гүйцэтгэл, чанарт хяналт, шаардлага тавих
- ✓ Тогтоосон хугацаанд төлбөрийг бүрэн төлөх
- ✓ Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлаа хангаж ажиллаж байгаа эсэхэд шаардлага тавих
- ✓ Цогцолборын дотоод журам биелүүлэхийг шаардах

**Хавсралт 23**




**Хавсралт 24**


2023 оны байгаль орчны менежменти
төлөвлөгөөний биелэлтийн тайлан


кашимер

**Хавсралт 25**

НИЙСЛЭЛИЙН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
32 ДУГААР ХОРООНЫ
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ

Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг,
32 дугаар хороо, 384-ийн гарам 29-1, 18411
Утас: (976) 9832-3332, http://songinokhairkhan.ub.khural.mn

2023.09.20 № 52/09

танай ______________-ны № ______________-т

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ГАЗАР-т

Хүсэлт дэмжих тухай

Тус хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг " Хатант интернэшнл " ХХК нь ноос, ноолуур угаах, самнах, боловсруулах үйлдвэрийн чиглэлээр нь 2016 оноос Бордоо хэсгийн байршилд үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа болно.

Тус байгууллага нь дүүрэг, хорооноос зохиогдож байгаа олон нийтийг хамарсан ажил, уулзалт, хэлэлцүүлэгт тогтмол хамт олны төлөөлөлөө оролцуулан хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, ажиллахын зэрэгцээ 2023 оны байгаль орчны менежментын төлөвлөгөөний тайланг хорооны иргэдийн Нийтийн Хурлын зөвлөлийн гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн ажилласан.

Тус байгуулага нь 2023 оны 09 дүгээр сарын байдлаар үйлдвэрийн байрандаа иж бүрэн засвар хийж,тоног төхөөрөмжөө нэмж засварлан сайжруулаж,3500м2 талбай зүлэгжүүлэлтийг " Мастер грийн " ХХК -тай хамтран ногоон байгууламжийг бий болгосон. Тухайн орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүй иргэдийг ажлаар хангах нөхцөл бололцоог ханган ажиллаж байгаа болно.

Үйлдврийн орчны нийтийн эзэмшлийн талбайг камержуулан,нийтийн их цэвэрлэгээ,үер усны жалга судгийн цэвэрлэгээний ажилд идэвхтэй оролцохын зэрэгцээ хорооны эмзэг бүлгийн 133 хүүхдүүдэд " Эх үрсийн баяр "аар гарын бэлэг, хичээлийн хэрэгслэл олгох ажлыг зохион байгуулан нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллаж ирсэн.

Иймд тус байгууллагын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг дэмжих саналыг хүргүүлж байна.

ДАРГА Б.БАТЦЭЦЭГ